

## ДАМЖУУЛАН ОЛГОХ ТӨСЛИЙН ЗЭЭЛҮҮДИЙН 2017 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

Монгол улсын Засгийн газар 1994 онд Азийн хөгжлийн банктай, 1995 онд ХБНГУ-ын Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу Монголбанк КфВ банк болон АХБ-ны төслийн зээлийг банкуудад дамжуулан олгох үүрэгтэй оролцож байна.

### 1. КфВ банкны ЖДҮ-ийг дэмжих төслийн зээл

**Төслийн зорилго:** Экспортын чиглэлийн ЖДҮ-ийг хөгжүүлэх, санхүүгийн секторыг дэмжих.

**Эх үүсвэр:** Монгол улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 40 жилийн хугацаатай 8.7 сая еврогийн зээлийг жилийн 0.75 хувийн хүүтэйгээр хүлээн авсан.


**КфВ банкнаас Монголбанкинд олгосон зээлийн эргэн төлөлт:** Монголбанк КфВ банкинд жилд 2 удаа хуваарийн дагуу эргэн төлөлт хийдэг бөгөөд анх зээл авсанаас хойш нийт 2.66 сая еврог КфВ банкинд төлсөн. Ингэснээр энэхүү зээлийн үлдэгдэл 2017 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар 6.04 сая евро байна (Хүснэгт 1).

*Хүснэгт 1. КфВ төслийн зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл /евро/*

	2016.II	2016.III	2016.IV	2017.I	2017.II	2017.III
Эхний үлдэгдэл	6 469 117,87	6 327 266,00	6 327 266,00	6 185 414,13	6 185 414,13	6 043 562,26
Үндсэн зээлийн төлбөр	141 851,87	0,00	141 851,87	0,00	141 851,87	0,00
Хүүгийн төлбөр	24 259,19	0,00	23 727,25	0,00	23 194,00	0,00
Эцсийн үлдэгдэл	6 327 266,00	6 327 266,00	6 185 414,13	6 185 414,13	6 043 562,26	6 043 562,26

**Монголбанкнаас Банкинд олгосон зээл:** Банкнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монголбанк 250 000 хүртэлх еврог 5 жилийн хугацаатай банкуудаар дамжуулан олгодог. Банк Монголбанкинд жилд 2 удаа хуваарийн дагуу буцаан төлдөг бөгөөд 2017 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар оролцогч банкуудаар дамжуулан олгосон зээлийн үлдэгдэл 4.22 сая евро байна. Тайлант хугацаанд Монголбанкнаас КфВ төслийн эрсдлийг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор эцсийн зээлдүүлэгчид шалгуур үзүүлэлтийг өөрчилж байгаа тул банкуудад эх үүсвэр олгохыг түр зогсоогоод байна (Зураг1).

Зураг 1. КфВ төслийн зээлийн үлдэгдэл, дамжуулан олгосон дүн



**Эх үүсвэрийн ашиглалт:** Тайлант хугацааны эцсийн байдлаар хөтөлбөрийн эргэлтийн сангийн хөрөнгийн 71.0 хувийг дамжуулан олгосон байна. КфВ төслийн ашиглаагүй эх үүсвэрийн үлдэгдэл 2017 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар 1,8 сая евро буюу 5.2 тэрбум төгрөг\* байна (Зураг1).

**Банкуудын ААН-д олгосон зээл:** КфВ банкны төсөл манай улсад хэрэгжиж эхэлснээс хойш уг төсөлд нийт 161 ЖДҮ зээлд хамрагдаж, 81.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авсан байна. Тайлант улирлын эцсийн байдлаар 64 ЖДҮ эрхлэгч ААН-үүд 12.2 тэрбум төгрөг /4.2 сая евро/-ийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нэг зээлдэгчид ногдож буй дундаж зээлийн хэмжээ 191.2 сая төгрөг байна.

## 2. АХБ-ны Ажлын байр нэмэгдүүлэх (АБН) төслийн зээл

**Төслийн зорилго:** Монгол улс, АХБ-ны хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийн зорилго нь хувиараа хөдөлмөр эрхлэх хэлбэрээр жижиг үйлдвэрлэл эрхэлж буй иргэдийг дэмжих, мөн ажлын байр нэмэгдүүлэхэд оршино.

**Эх үүсвэр:** Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу 2154.0 мянган зээлжих тусгай эрхтэй (ЗТЭ) тэнцэх валютыг 40 жилийн хугацаатай зээлсэн.

**АХБ-наас Монголбанкинд олгосон зээлийн эргэн төлөлт:** Анх зээл авсанаас хойш нийт 767.3 мянган ЗТЭ-ийг төлсөнөөр 2017 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар зээлийн өрийн үлдэгдэл 1,305.1 мянган ЗТЭ буюу 4.5 тэрбум төгрөг\*\* байна.

**Банкинд дамжуулан олгосон зээл:** Банкнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монголбанк 30 сая хүртэлх төгрөгийг 2 жилийн хугацаатай банкуудаар дамжуулан олгодог. 2017 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар оролцогч

\*-2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн ханшаар тооцов.

банкинд олгосон эх үүсвэрийн үлдэгдэл 681 сая төгрөг байгаа бөгөөд төслийн эргэлтийн санд зээлдүүлэх боломжтой 3.8 тэрбум төгрөгийн эх үүсвэр байна (Зураг 2).

Зураг 2. АХБ-ны АБН төслийн зээлийн үлдэгдэл, дамжуулан олгосон дүн



Банкуудын тайлангаас үзэхэд 2017 оны 3 дугаар улирлын байдлаар зээлийн үлдэгдэлтэй байгаа 37 аж ахуй нэгж нийт 111 ажлын байр бий болгосон байна.

\*\* - 2017 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн ханшаар тооцов.